



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/20

Улаанбаатар хот

Спортын төв ордны “А” заалны  
ашиглалтын журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын төв ордны “А” заалны ашиглалтын журмыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

142310405

Биеийн тамир, улсын хорооны даргын  
2023 оны 04 дүгээр сарын 25-ний  
өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт



## **“А” ЗААЛ АШИГЛАЛТЫН ЖУРАМ**

### ***Нэг.Нийтлэг үндэслэл***

- 1.1 Энэхүү журам нь Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын төв ордон дахь “А” зааланд спортын болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, түрээслүүлэх, түрээсийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Спортын болон нийтийг хамарсан арга хэмжээ нь биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны чиглэл, зорилготой уялдуулан заал ашиглалт, түрээсийн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.3 Түрээслэгч нь заал танхимыг ашиглах талаарх мэдээллийг түрээслэгч талд 3 (гурав)-аас доошгүй сарын өмнө урьдчилан мэдэгдэж, график төлөвлөгөөнд тусгуулан гэрээ байгуулж, зохих тарифын дагуу төлбөрийг хийнэ.
- 1.4 Түрээслэгч талын хүсэлтийг албан бичиг, цахимаар авч, заал ашиглалтын төлөвлөгөөнд тусгаж, гэрээ байгуулна.
- 1.5 Заал ашиглахтай холбогдсон өдөр тутмын үйл ажиллагааг заалны асуудал хариуцсан ажилтан Спортын төв ордны менежер зохион байгуулах үүрэгтэй бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газрын өмнө хариуцлага хүлээнэ.
- 1.6 Заал ашиглах түрээсийн гэрээ байгуулах, төлбөр тооцооны гүйцэтгэл болон журмын хэрэгжилтэд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хяналт тавина.

### ***Хоёр.Заалны цаг ашиглалт, дотоод журам***

- 2.1 Зааланд зохиогдох аливаа арга хэмжээний үргэлжлэх хугацаа 5 (тав) цаг хүртэл бол хагас өдөр түүнээс дээш хугацааг бүтэн өдрийн тарифаар тооцох ба оройн 22.00 цагаас хойш илүү цагийн төлбөр авна.
- 2.2 Заалыг гэрээнд заасан нөхцөл зориулалтын дагуу ашиглах бөгөөд байгууллагын болон заалны эд хогшлыг гэмтээх, зааланд тамхи татах, архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.
- 2.3 Амралтын өдөр түрээсэлж байгаа тохиолдолд заал ашиглахтай холбоотойгоор ажиллуулах үйлчилгээний ажиллагсдын илүү цагийн хөлсийг тооцон түрээсийн төлбөр дээр нэмж тооцно.
- 2.4 Тэмцээний удирдамж, шүүгчдийн бүрэлдэхүүн, спортын хэрэгсэл, материал хангамжтай холбогдсон асуудлыг түрээслэгч тал өөрөө шийдвэрлэх бөгөөд гадна талбай болон заал танхимд тавигдах реклам сурталчилгааны материалыг түрээслүүлэгч талтай тохиролцсоны үндсэн дээр байрлуулах буюу заалны зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.
- 2.5 Түрээслэгч талд шаардлагатай эд зүйлс, заал танхимыг тэмцээн эхлэх цагаас 30-60 минутын өмнө бэлэн болгоно.
- 2.6 Түрээсийн гэрээ байгуулсан боловч арга хэмжээ зохиогдохоос 3 хоногийн өмнө төлбөр тооцоогоо хийгээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгон цуцалж болно.

### ***Гурав.Төлбөр тооцоо***

- 3.2. Арга хэмжээ зохиогдохоос 3 хоногийн өмнө заалны түрээсийн төлбөрийг Биеийн тамир, спортын хорооны Төрийн сан банк дахь 100900008433 тоот дансанд түрээсийн төлбөрийг нэхэмжлэлийн дагуу хийнэ. Хэрвээ түрээсийн төлбөр хийгдээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгон цуцална.
- 3.1 Цагийн хөлс нь 100,000 (нэг зуун мянга) төгрөг, илүү цагийн төлбөр 300,000 (гурван зуун мянга), нэг өдрийн түрээсийн төлбөр нь ажлын өдөр бол 800,000 (найман зуун мянга) төгрөг, амралтын өдөр бол 1,500,000 (нэг сая таван зуун мянга)төгрөг байна.
- 3.2 Хэрвээ олон улсын чанартай хурал цуглаан, шашны аливаа зан үйл үйлдэх (бясалгал, номлол, цуглаан г.м) болон бусад олон нийтийг хамарсан цуглаан, уулзалт семинар, спортын бус бусад арга хэмжээ зохион байгуулахаар бол заалны түрээсийн төлбөр нь өдөрт 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөг байна.
- 3.3 Спортын топ төрлүүд болох Монгол улсын үндэсний шигшээ баг байгуулсан төрлүүдээр насанд хүрэгчид, өсвөр, залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Спортын төв ордны А зааланд үнэ төлбөргүй түрээслүүлнэ.
- 3.4 Хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдийн төлөөх олон нийтийн байгууллага, нийгмийн төлөөх тусгай спортын арга хэмжээ зохиогдох тохиолдолд БТСУХ-ны даргын зөвшөөрөлтэйгөөр үнэ төлбөргүй болон 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй тарифаар ашиглуулж болно.

#### ***Дөрөв.Зааланд сурталчилгаа байршуулах***

- 4.1 Спортын төв ордны 7 ширхэг том цонхонд 1 жилийн хугацаанд 25-30 сая.төгрөгөөр байршуулна.
- 4.2 Сурталчилгааг тэмцээн зохион байгуулж буй байгууллага гэрээний хугацаанд үнэ төлбөргүйгээр Спортын төв ордны баруун талын 128м<sup>2</sup> талбай бүхий хана, спортын төв ордны гадна талбайн 18м<sup>2</sup> самбарт байршуулж болно.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР